



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛ

Эрчим хүчний яамны Шинжлэх Ухаан, Технологийн Зөвлөлийн 6 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит IV хуралдааны 12 дугаар тэмдэглэлд:

### Хэлэлцсэн асуудал № 4:

Эко хорооллын тархмал нарны цахилгаан үүсгүүрийн техник эдийн засгийн үндэслэл


### Хэлэлцүүлэгч:

“Электро Инженеринг” ХХК, “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Улаанбаатар хотод барьж байгуулах “Эко хорооллын тархмал нарны цахилгаан үүсгүүрийн техник эдийн засгийн үндэслэл”-ийг бодлогын хувьд дэмжин, төслийг Эрчим хүчний сайдын 2020 оны А/159 дүгээр тушаалаар баталсан “Хэрэглэгчдийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журам”-ын хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй.
2. “Эрчим хүчний барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад тавигдах шаардлага” журмын дагуу нэр бүхий техник эдийн засгийн үндэслэлийн тайланг 2 хувь албан хэвлэл, 1 хувь цахим CD хэлбэрээр Зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгөх.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД САЙД, ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  М.БАЯРМАГНАЙ

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Ж.ГЭРЭЛ

2023 оны 6 дугаар сарын 30